



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2017-12-20 № 19

Асуулга тавих тухай

Монгол Улсад Уул уурхайн ашиглалт, байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин 1988 оноос эхлэн бүрэлдэж, холбогдох хуулиуд болох Ашигт малтмалын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, зэрэг хуулиуд батлагдан мөрдөгдсөөр байна.

Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын салбарт ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүд, бичил уурхай эрхлэгч иргэд ихээр нэмэгдэж байгаа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж, нөхөн сэргээлт хийгдэхгүй орхигдсоор байна.

“Бичил уурхайчид” хэмээн нэрлэдэг гар аргаар алт, жонш, нүүрс болон бусад төрлийн уул уурхайн бүтээгдэхүүн олборлогчид байгаль орчинг ихээр сүйтгэсээр байна. 2016 оны байдлаар 16 аймгийн 34 сумын нутаг 1637.71 га талбай бүхий 96 нэгжид бичил уурхайн олборлолт явагдаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Байгаль орчны төлөв байдлын тайланд” Эвдэрсэн газрын тооллогын дүнгээс үзэхэд 2012 оны байдлаар 20 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан 699 нэгж талбар бүхий 4256 га талбай нөхөн сэргээлт хийгдээгүй, хариуцах эзэнгүй орхигдсон байна.

Эвдрэлд орсон талбайн 60% нь аж ахуйн нэгж байгууллагын, үлдсэн 40% нь гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд өртжээ. Эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээхэд 1 га талбайд дунджаар 25.0 сая төгрөгөөр тооцоход нийт 80-100 тэрбум төгрөгийн төсөв шаардлагатай гэсэн тооцоо гарсан байна. Дээрхи тооцоо судалгаанаас харахад байгаль орчин, ашигт малтмалын болон бусад холбогдох хууль тогтоомжууд хангалтгүй хэрэгжиж байгаль орчин ихээр сүйдэж, иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдөж байна гэж үзэж байна.

Иймд миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг танд хандан тавьж байна. Үүнд:

1. 2016-2017 онд Байгал орчны болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хэдэн аж ахуй нэгж байгууллага, иргэдээр хичнээн га талбай газарт нөхөн сэргээлт хийлгэсэн, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө болох нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2017 оны байдлаар хэдэн төгрөг байршсан талаарх тодорхой мэдээлэл ирүүлэх;

2. Монгол Улсын Эрүүгийн хуулинд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах олборлох, байгаль орчин нөхөн сэргээхтэй холбоотой гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхой дурдсан. Тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1, 24.2.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээд, иргэдтэй тэмцэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан талаар;
3. Ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, байгаль орчин нөхөн сэргээхтэй холбоотой төрийн байгууллагаас гаргасан хичнээн хууль бус шийдвэр, тусгай зөвшөөрлийг цуцалсан, хууль бус шийдвэр гаргаж төрд хохирол учруулсан, хэдэн албан тушаалтанд хариуцлага тооцож, хэдэн га газарт төрийн зардлаар нөхөн сэргээлт хийсэн, хэдэн төгрөгийн хохирол учирсныг буруутай этгээдээр төлүүлсэн талаарх тодорхой хариу ирүүлнэ үү.

Эдгээр асуудлыг Засгийн газар анхааралдаа авч судлан хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН

ГИШҮҮН

*Х.Нямбаатар* Х.НЯМБААТАР